



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 2 сарын 10 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### IV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын IV хурал 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 16.00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 80 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №02 тушаалаар БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудад ажилласан комиссын Шуурхай бүлгийн мэдээлэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Улсын онцгой комиссын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян;

2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тусгай эмнэлэг бэлтгэх ажлын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлнарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор монголын уламжлалт сар шинийн баярыг нийтээр тэмдэглэхгүй байх Улсын онцгой комиссын саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүнд уламжлан шийдвэрлүүлэхээр тогтов.

#### Нэг. Засгийн газрын

Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

1.1. Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолд заасан хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын орон тооны хязгаарт багтсан эрүүл ахуй, улсын хяналтын 58 байцаагчийг шууд томилох асуудлыг судлан шийдвэрлэхийг;

Хоёр. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

2.1. Шинэ коронавирусийн болзошгүй эрсдэлээс хүн амыг урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн салбар болон төрийн бусад байгууллагын албан хаагчдад нэн хэрэгцээтэй байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бодис худалдан авах, нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэх эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгохыг;

Гурав. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,

Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

хошууч генерал Т.Бадрал нарт:

3.1.Коронавирусийн халдварын сэжиг илэрсэн тохиолдолд нийслэлийн хэмжээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг, зайлшгүй тохиолдолд “Асралт мед” эмнэлэг, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийг тусгайлан бэлтгэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг;

3.2. Хилийн бүс нутагт байрлах Замын-Үүдийн 100 ортой эмнэлэг, Сайншанд сумын 50 ортой эмнэлгийн барилгын ажил дуусч, 2019 оны 10 дугаар сарын 22-нд нээлтээ хийсэн байхад одоог хүртэл гэрээ байгуулаагүй, төсөвт тусгагдсан санхүүжилтийг олгоогүй, ашиглалтад хүлээж аваагүй байгаад дүгнэлт хийх;

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хилээр нэвтэрч байгаа өвчний сэжиг илэрсэн зорчигч, иргэдийг түр тусгаарлан байрлуулах зорилгоор

хилийн бүсэд байгаа дээрх эмнэлгүүдийн барилгын гэрээг байгуулж, төсөвт тусгагдсан санхүүжилтийг олгон, ашиглалтанд хүлээж авах ажлыг яаралтай зохион байгуулж, Улсын онцгой комисст танилцуулахыг;

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,  
Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин,  
Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар,  
Ховд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав,  
Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт:

4.1. Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс тээвэрлэлтийг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл зогсоож, холбогдох арга хэмжээг авахыг;

4.2. Улсын хилээр амны хаалт экспортлохыг хориглож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг;

4.3. Улсын хилээр нэвтрүүлж байгаа ачаа, бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийн гадаргууны ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэхийг;

Тав. Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,  
Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж,  
Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
хошууч генерал Т.Бадрал нарт:

5.1. ХӨСҮТ-өөс гаргасан стандартын дагуу цэргийн оёдлын үйлдвэр “Бөртэ”, Хил хамгаалах ерөнхий газрын 0288 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий

газар, Цагдаагийн ерөнхий газрын оёдлын үйлдвэрүүдэд амны хаалт оёж, улсын нөөцийн нөөц бүрдүүлэлтийг нэмэгдүүлж, иргэдийг хангах ажлыг зохион байгуулахыг;

Зургаа. Аймаг, нийслэлийн Засаг дарга,


Онцгой комиссын дарга нарт:

6.1. Аймаг, нийслэлийн хэмжээнд амны хаалтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг;

6.2. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг байгууллага тус бүрээр тооцож, хэмнэгдсэн зардлыг ариутгал, халдваргүйтгэлийн зардалд шилжүүлэх замаар төсвийн эдийн засгийн ангилалд зохицуулалт хийж санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгов:

ДАРГА,

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН